



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1997 оны 3 дугаар
сарын 05 өдөр

Дугаар

6-19

Улаанбаатар
хот

Статистик мэдээлэл, судалгааны албаны
дүрэм бетлах, ажилд томилох тухай

1. Монгол улсын Засгийн газрын 1996 оны 263 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 1997 оны Б/18 дугаар захирамжийг үндэслэн нийслэлийн Статистик мэдээлэл, судалгааны албаны дүрмийг хэвсралтаар баталсугай.
2. Нийслэлийн Статистик мэдээлэл, судалгааны албаны даргаар Вандангийн Очирпүрэвийг 1997 оны 03 дугаар сарын 01-нээс томилж, сарын үндсэн цалинг 34950 төгрөгөөр, нэмэгдлийг үндсэн цалингийн 60 хувиар бодож тогтоосугай.
3. Албаны албан хаагчдыг ажилд томилж, цалин нэмэгдлийг холбогдох журмын дагуу тогтоож ажиллахыг Статистик мэдээлэл, судалгааны алба (н.Очирпүрэв) -нд даалгасугай.
4. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 1994 оны А/109 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



[Handwritten signature]

Ж.НАРАНЦАЦРАЛТ



**Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Статистик, мэдээлэл,
судалгааны албаны дүрэм**

НЭГ. Нийтлэг үндэслэл.

1.1. Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Статистик, мэдээлэл, судалгааны алба нь нийслэлийн нутаг дэвсгэр дээр статистик, мэдээлэл, судалгааны үйл ажиллагааг явуулах төрийн захиргааны орон нутгийн байгууллага мөн.

Статистик, мэдээлэл, судалгааны албаны бүтцэд хотын улсын архив, музей харъяалагдах бөгөөд хотын улсын архив, музей нь өөрийн дүрмийн дагуу үйл ажиллагаагаа явуулна.

1.2. Статистик, мэдээлэл, судалгааны алба нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Статистикийн тухай хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Засаг захиргааны хариуцлагын тухай хууль болон бусад хуулиуд, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамж, Статистикийн төв байгууллагын даргын тушаал зааврыг удирдлага болгон ажиллана.

1.3. Алба нь Нийслэлийн Засаг Дарга, түүний тамгын газрын харьяанд үйл ажиллагаагаа явуулж ажлаа тайлагнана.

1.4. Статистик, мэдээлэл, судалгааны албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоог Нийслэлийн Засаг дарга тогтоож, албаны даргыг томилж, чөлөөлнө.

1.5. Статистик, мэдээлэл, судалгааны албаны дарга нь эрх хэмжээний асуудлаар тушаал гаргана.

1.6. Статистик, мэдээлэл, судалгааны алба нь тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

1.7. Статистик, мэдээлэл, судалгааны албаны дарга нь дэргэдээ Зөвлөлтэй байж болно.

ХОЁР. Статистик, мэдээлэл, судалгааны албаны үүрэг

2.1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай, Монгол улсын статистикийн тухай хуулиудыг хэрэгжүүлэх түүний дотор Нийслэлийн Засаг даргын Статистикийн талаарх бүрэн эрхийг нийслэлийн нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлж статистикийн албан ёсны мэдээллийг мэдээлэгчдээс хугацаанд нь гаргуулан авч нэгтгэх, төвд мэдээлэх, статистикийн төрөл бүрийн тооллого, түүвэр судалгааг зохион байгуулж явуулах, нийслэл хотын хөгжил түүх, нийслэлийн олон талт үйл ажиллагааны талаар олон түмний санаа бодолыг судлан шинжилгээ, судалгаа хийж нийслэлийн удирдлагад танилцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон түмэнд мэдээлэх, сурталчлах

2.2. Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд төр захиргааны байгууллагуудын мэдээллийн нэгдсэн сүлжээ, нийслэлийн нэгдсэн болон салбарын мэдээллийн сангууд бий болгож төсөл, программ хангамжийг боловсруулах, мэдээллийн сангуудыг баяжуулах, компьютерийн болон бусад техник хэрэгслээр хангах, техник ашиглалтыг сайжруулах, мэдээлэл, тооцооллын ажилд шаардлагатай техник хэрэгслийг сонгон авч захиалах, суурилуулах, шинэчлэх ажлыг боловсруулан хэрэгжүүлэх, нэвтрүүлэх

2.3. Нийслэлийн төр захиргааны байгууллагууд болон бусад яам, газар, байгууллагуудын хооронд электрон шуудангаар мэдээлэл солилцох асуудлыг боловсруулж, шийдвэрлүүлэх

2.4. Нийслэлийн төр, захиргааны байгууллагуудын мэдээллийн дотоод болон нэгдсэн сүлжээ, мэдээллийн сангийн хамрах хүрээ, мэдээллийн урсгал, давтамжийг тогтоох, эдгээр сүлжээг ажиллуулах, ашиглах журам боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих

2.5. Нийслэлийн эдийн засаг нийгмийн байдлыг сар бүр нэгтгэн дүгнэж, танилцуулга, статистикийн эмхэтгэл гаргах, хэвлэлийн эх бэлтгэх, олшруулах ажлыг хариуцан хийх

2.6. Нийслэлийн эдийн засаг нийгмийн үндсэн үзүүлэлтүүдээр олон жилийн зэрэгцүүлэлт хийх, статистикийн мэдээллийн нэгдсэн болон дэд санг байгуулах, баяжуулах, ашиглах

2.7. Нийслэл Хотын судлал, түүнтэй холбоотой судалгаа эрдэм шинжилгээний эрхлэх нийслэлийн хөгжлийн судалгааны асуудлаар судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгэнэ.

2.8. Нийслэлийн удирдлага, Тамгын газрын, нийслэлийн Засаг даргын харьяа хэрэгжүүлэгч агентлаг газар хэлтэс тасгуудад нийслэлийн эдийн засаг нийгмийн болон хот, нийтийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл судалгаагаар хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр олон түмэнд мэдээлэх сурталчлах

2.9. Дүүргийн статистикийн албадыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэдний мэргэжил, мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд туслалцаа үзүүлэх, нийслэл, дүүргийн засаг даргын тамгын газар, нийслэлийн засаг даргын захирагчийн ажлын алба, засаг даргын дэргэдэх байгууллагуудын ажилтануудад компьютерийн мэдлэг эзэмшүүлэх сургалт явуулах, мэдээлэл, тооцооллын ажлын талаарх нэгдсэн заавар, аргачлалаар хангах, хяналт тавих

2.10. Монгол Улсын Статистикийн тухай хуулийг нийслэлийн нутаг дэвсгэр дээр хэрэгжүүлэх, хэрэгжилтийн байдалд хяналт тавих

2.11. "Төрийн нууцын тухай, Байгууллагын нууцын тухай, Хувь хүний нууцын тухай" хуулиудын дагуу нууцын зэрэглэлд орох мэдээллийн нууцыг чандлан хадгалах

ГУРАВ. Статистик, мэдээлэл, судалгааны албаны эрх

3.1. Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлаж үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байгаа (өмчийн бүх хэлбэрийн) улсын үйлдвэрийн газар, компани, нөхөрлөл, хувиараа эрхлэх аж ахуй, төсөвт байгууллага, Монгол улсын болон гадаадын

харьяат, харьяалалгүй иргэд (мэдээлэгч)-ээс статистикийн албан ёсны төвлөрсөн болон төвлөрсөн бус мэдээллийг баталсан маягт, зааврын дагуу авах

3.2. Статистикийн төв байгууллага болон нийслэлийн төр захиргааны байгууллагаас өгсөн чиглэл, удирдамжын дагуу бүх төрлийн тооллого, бүртгэл, түүвэр судалгааг зохион байгуулах

3.3. Нийслэлийн удирдлагын үйл ажиллагаанд хэрэглэгдэх мэдээлэл судалгааг нийслэлийн Засаг даргын тамгын газар, Засаг даргын дэргэдэх болон харъяа газар, байгууллагаас авах

3.4. "Нийслэлийн мэдээллийн сүлжээ" төслийн хүрээнд хийгдсэн дотоод сүлжээг ашиглаж мэдээлэл солилцох, нийслэлийн мэдээллийн нэгдсэн сүлжээг өргөтгөх, ашиглалтыг сайжруулж хяналт тавих

3.5. Мэдээлэл, тооцооллын ажилд шаардлагатай компьютер болон бусад техник хэрэгслэлийг оновчтой сонгож захиалах, суурилуулах, шинэчлэх, нэвтрүүлэх

3.6. Нийслэлийн төр захиргааны байгууллагуудаас мэдээллийн сүлжээ болон сан байгуулах ажилд шаардлагатай тоо, материал, судалгаа гаргуулан авах

3.7. Дүүрэг, хороодын засаг даргын статистикийн мэдээллийн талаархи бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд нь мэргэжлийн заавар зөвлөлгөө өгөх, аргачлал заавраар хангах, хяналт тавих

3.8. Статистикийн мэдээ тайлангийн маягт, заавар үзүүлэлтийг боловсронгуй болгох талаар саналаа статистикийн төв байгууллагад тавих

3.9. Дүүрэг хороодын статистикийн ажилтнаас улсын статистикийн байцаагчаар томилуулах саналаа статистикийн төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх

3.10. Статистикийн тухай хуулинд зааснаас бусад тохиолдолд статистикийн төв байгууллага болон нийслэл Засаг даргаас батлаагүй буюу зөвшөөрөгдөөгүй статистикийн мэдээ тайланг давхардуулан авах ажиллагааг зогсоох